



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/556

Есөнбулаг

Гамшгийн сангаас хөрөнгө зарцуулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө, аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээл бэлтгэх зардал, Бугат сумын Эрүүл мэндийн төвөөс яаралтай тусламжаар хүргэгдэж ирсэн тарваган тахлын сэжигтэй тохиолдлыг хүлээн авч, голомтод ажилласан эмч, эмнэлгийн ажилчдын нөхөн олговор, Нарлаг хорооллын 5, 7 дугаар байрны бохир усны шугам засварлах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 136,251,665 (нэг зуун гучин зургаан сая хоёр зуун тавин нэгэн мянга зургаан зуун жаран тав) төгрөгийг аймгийн Гамшгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20. А оны
69 дугаар сарын 14 ны өдрийн 556 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Нийт дүн (төгрөг)
1.	Аймгийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах, аюулгүйн нөөцийн өвс бэлтгэх зардал	65,000,000
2.	Аймгийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах, аюулгүйн нөөцийн тэжээл бэлтгэх зардал	55,000,000
3.	Тарваган тахлын голомтод ажилласан эмч, эмнэлгийн ажилчдын нөхөн олговор	3,737,865
4.	Есөнбулаг сумын Оргил багийн Нарлаг хорооллын 5, 7 дугаар байрны бохир усны шугам шинэчлэх зардал	12,513,800
	Дүн	136,251,665

__оОо__

